

Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан

Төслийн нэр

ТТ хэлцэл 9607-МОН:
Хүнсний ногооны
үйлдвэрлэл ба
усалгаатай газар
тариалан (51423-001)

Гэрээний дугаар

146268- S53349

Төсөл эхлэх хугацаа

2019 оны 2 дугаар сар

Дуусах хугацаа

2019 оны 8 дугаар сар

Захиалагч

Азийн хөгжлийн банк
(АХБ)

Ашиг хүртэгч

Монгол улсын засгийн
газар

Зөвлөх баг

Landell Mills Ltd
Bryer-Ash Business Park
Trowbridge BA14 8NE
United Kingdom
Tel +44 1225 763777

Холбоо барих хаяг:

Төслийн менежер:
Jessica Morrissey
JessicaM@landell-
mills.com

Монголын Усны Форум -
Усхэлц ТББ
Улаанбаатар, БЗД
Токүогийн гудамж 1-73-1

Холбоо барих хаяг:

Ерөнхий захирал
П.Батица
batima@mwf-mn.org

Web: www.mwf-mn.org

Ерөнхий зүйл

Энэхүү “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан” техник туслалцааны хэлцлийн төсөл нь Монгол орны газар тариалангийн салбарын хүнсний ногооны ургац, зах зээлийг нэмэгдүүлж орон нутагт жижиг тариаланчдын орлого, ажлын байр нэмэгдүүлэх чиглээр хэрэгжүүлэх төсөлд дэмжлэг үзүүлнэ. Хүнсний ногоо үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тулгарах олон саад бэрхшээлийг даван туулахад хүнсний ногооны нэмүү өртгийг нэмэгдүүлэх, зах зээлийн сүлжээг бэхжүүлэх асуудал маш чухал юм. Үүний тулд (i) хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлэх, (ii) хүнсний ногооны нэмүү өртгийг нэмэгдүүлэх зах зээлийн сүлжээг өргөтгөх дэд бүтэцийг сайжруулах гэсэн үндсэн хоёр чиглэлд анхаарах шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэхэд нийт 42.4 сая ам. долларын хөрөнгө шаардлагатай бөгөөд энэхүү санхүүжилтийн 40 сая нь АХБ-ны зээл, 2 сая нь буцалтгүй тусламж, 0.4 сая Монгол улсын Засгийн газрын хөрөнгөөс бүрдэнэ.

Төслийг хэрэгжүүлэгч нь Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байна. Төслийн хэрэгжилт нь салбарын хөгжлийн дэмжих төслийн бичиг баримтад заасан арга зүй, аргачлалыг мөрдлөг болгоно. Тухайлбал энэхүү төсөл нь салбарын хөгжилд шаардлагатай их хэмжээний хөрөнгө оруулалт болон тодорхой бус олон төслийг хэрэгжүүлэх асуудалд бус зөвхөн тодорхой нэг үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалтанд анхаарах юм.

Техник туслалцааны хэлцлийн төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажил

Энэхүү Техник туслалцааны хэлцлийн төслийн хүрээнд АХБ-аас Монгол улсын засгийн газарт хөдөө аж ахуйн салбарт зээл олгох шийдвэр гаргуулах бичиг баримтыг боловсруулна.

Төслийн зорилго: (i) баримт бичигт төсөл хэрэгжих болон үр ашгийг дээшлүүлэх хамгийн шинэ, шинэлэг санаа, концепт, технологи, болон менежментийн арга барилыг тусгасан бүрэлдэхүүн хэсгийг багтааж АХБ-ны зээл олгох журамд нийцүүлэх, (ii) санал болгож буй төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн техник, эдийн засаг, санхүү, засаглал, нийгэм, байгаль орчны аюулгүй байдал болон эрсдэлийг бууруулах арга хэмжээг анхаарч судлах (iii) төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллага болон тэдгээрийн төсөл хэрэгжүүлэх нэгж, өөр бусад холбогдох оролцогч талуудад төслийг хэрхэн үр ашигтай байхаар боловсруулах мөн төсөл хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх сургалт хийх (iv) төслийн үйл ажиллагааг бүх түвшинд зохион байгуулах; (v) төслийн бичиг баримтыг хамгийн сайн чанартай боловсруулах (vi) төслийн үе шат бүрийг цаг хугацаанд нь гүйцэтгэж ажлын төлөвлөгөөг мөрдөх (iv) боловсруулах төслийн баримт бичигт техник эдийн засгийн үнэлгээний тайлан, зээлийн баталгаа, АХБ-ны тайлангийн төсөл, болон АХБ-ны ерөнхийлөгчийн зөвлөмж багтана.

Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан

Гарах үр дүн

Энэхүү Техник туслалцааны хэлцлийн төсөл нь Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг хөгжүүлэхэд чиглэсэн дараах үр дүнг гаргана. Үүнд:

- Техник эдийн засгийн үнэлгээ хийж техникийн загвар гаргана.
- Нийгэм, байгаль орчин, хүйсийн тэгш үнэлгээ хийнэ.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон ажил үйлчилгээ худалдан авах багц бичиг баримт боловсруулна.
- Хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагын төсөл хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлнэ.

